



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /37/ НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70358033 Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Хэрлэнзаяа Утас: 70357955 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn</p>
-----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2-3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн, санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1. Залруулсан алдаа	14
4.2 Албан шаардлага.....	14
4.3 Зөвлөмж.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 70
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ОДОНЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,236,500.93	52,939,503.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
33	АВЛАГА	357,354.79	357,354.79
335	Бусад авлага	357,354.79	357,354.79
3351	Байгууллагаас авах авлага	357,354.79	357,354.79
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	61,879,146.14	52,582,148.87
351	Түүхий эд материал	56,881,886.14	49,647,008.87
35110	Тусгай зориулалттай материал	55,769,586.14	49,174,208.87
35130	Эм боох материал	1,112,300.00	472,800.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	4,997,260.00	2,935,140.00
35410	Бичиг хэргийн материал	886,500.00	543,100.00
35420	Аж ахуйн материал	2,266,340.00	1,818,540.00
35450	Барилгын засварын материал	270,500.00	20,000.00
35460	Хүнсний материал	1,573,920.00	553,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,132,736,108.87	1,100,338,257.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,132,736,108.87	1,100,338,257.52
391	Газар		
392	Биет хөрөнгө	867,606,108.94	835,288,257.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	820,434,553.46	820,434,553.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,210,375.04)	(70,815,562.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,236,152.00	54,521,652.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,664,079.59)	(35,990,484.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,171,382.22	41,171,382.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,430,870.58)	(33,489,648.54)
39209	Зам, гүүрийн байгууламж	71,750,751.57	71,750,751.57
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,681,405.10)	(12,294,385.78)
393	Биет бус хөрөнгө	265,129,999.93	265,049,999.89
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(140,000.07)	(220,000.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	264,870,000.00	264,870,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,194,972,609.80	1,153,277,761.18

2.2 Аудит хийсэн, санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	400,618,452.00	377,619,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,924,352.00	9,000,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,924,352.00	9,000,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,924,352.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,924,352.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		3,285,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		5,714,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	378,694,100.00	368,619,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,576,100.00	352,218,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,576,100.00	352,218,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,000.00	355,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000.00	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,046,000.00	16,046,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,046,000.00	16,046,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	422,049,188.11	419,314,548.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,049,188.11	419,314,548.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,149,949.10	417,717,092.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,886,900.00	296,446,354.82
210101	Үндсэн цалин	189,466,998.81	170,857,800.00
210102	Нэмэгдэл	79,071,201.19	99,318,654.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,168,800.00	2,721,561.00
210104	Урамшуулал	22,179,900.00	23,548,339.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,539,700.00	41,005,957.58
210201	Тэтгэврийн даатгал	27,824,300.00	29,072,457.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,928,900.00	2,983,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,343,100.00	2,386,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	585,800.00	596,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,857,600.00	5,966,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,903,710.99	13,393,283.28
210301	Гэрэл, цахилгаан	1,171,129.50	1,477,783.51
210302	Түлш, халаалт	7,939,835.25	7,267,536.42
210303	Цэвэр, бохир ус	5,792,746.24	4,647,963.35

2104	Хангамж, бараа материалын зардал	13,290,800.00	9,699,815.87
210401	Бичиг хэрэг	7,586,050.00	2,625,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,300.00	132,538.60
210404	Ном, хэвлэл		2,477,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,688,650.00	971,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,937,800.00	3,492,727.27
2105	Нормативт зардал	19,476,810.00	17,251,030.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	653,050.00	483,200.00
210502	Хоол, хүнс	18,623,460.00	12,875,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,300.00	3,892,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,392,600.00
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,392,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,189,928.11	38,528,051.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	181,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,532,500.00	2,663,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,257,428.11	35,683,351.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,899,239.01	1,597,455.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,640,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,640,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,259,239.01	1,597,455.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,259,239.01	1,597,455.72
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-21,430,736.11	-41,694,848.62
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-21,430,736.11	-41,694,848.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,018,684.00	688,389,013.18	38,564,912.62	1,194,972,609.80
2	Тайлант үеийн үр дүн			-41,694,848.62	-41,694,848.62
3				
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,018,684.00	688,389,013.18	-3,129,936.00	1,153,277,761.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	391,662,568.00	370,647,733.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,662,568.00	370,647,733.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,576,100.00	352,218,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	362,576,100.00	352,218,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,000.00	355,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000.00	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,046,000.00	16,046,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,046,000.00	16,046,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,968,468.00	2,028,233.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,968,468.00	2,028,233.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	393,718,989.00	370,647,733.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,718,989.00	370,647,733.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,484,960.99	367,022,044.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,886,900.00	296,446,354.82
210101	Үндсэн цалин	189,466,998.81	170,857,800.00
210102	Нэмэгдэл	79,071,201.19	99,318,654.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,168,800.00	2,721,561.00
210104	Урамшуулал	22,179,900.00	23,548,339.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,539,800.00	41,005,957.58
210201	Тэтгэврийн даатгал	27,824,300.00	29,072,457.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,928,900.00	2,983,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,343,100.00	2,386,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	585,800.00	596,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,857,700.00	5,966,700.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,903,710.99	13,393,283.28
210301	Гэрэл, цахилгаан	1,171,129.50	1,477,783.51
210302	Түлш, халаалт	7,939,835.25	7,267,536.42
210303	Цэвэр, бохир ус	5,792,746.24	4,647,963.35
2104	Хангамж, бараа материалын зардал	5,883,100.00	1,245,288.60
210401	Бичиг хэрэг	168,700.00	140,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,300.00	132,538.60
210404	Ном, хэвлэл	60,500.00	24,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	5,098,800.00	413,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	476,800.00	534,800.00
2105	Нормативт зардал	20,002,650.00	12,335,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,600.00	45,400.00
210502	Хоол, хүнс	19,318,250.00	11,854,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,800.00	435,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,142,100.00
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,142,100.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,406,700.00	1,453,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	706,400.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700,300.00	1,453,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,234,028.01	3,625,688.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,974,789.00	2,028,233.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,334,789.00	2,028,233.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,640,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,259,239.01	1,597,455.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,259,239.01	1,597,455.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-2,056,421.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2,056,421.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,264,500.00	366,667,044.28	1,597,455.72	99.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,264,500.00	366,667,044.28	1,597,455.72	99.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,264,500.00	366,667,044.28	1,597,455.72	99.57

Орхон аймгийн 2-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,446,400.00	296,446,354.82	45.18	100
210101	Үндсэн цалин	170,857,800.00	170,857,800.00		100
210102	Нэмэгдэл	99,318,700.00	99,318,654.82	45.18	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,535,300.00	2,721,561.00	-186,261.00	107.35
210104	Урамшуулал	23,734,600.00	23,548,339.00	186,261.00	99.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,053,400.00	41,005,957.58	47,442.42	99.88
210201	Тэтгэврийн даатгал	29,119,900.00	29,072,457.58	47,442.42	99.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,983,400.00	2,983,400.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,386,700.00	2,386,700.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	596,700.00	596,700.00		100
210205	Эрүүл мэндийн даатгал	5,966,700.00	5,966,700.00		100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,903,900.00	13,393,283.28	1,510,616.72	89.86
210301	Гэрэл, цахилгаан	2,720,900.00	1,477,783.51	1,243,116.49	54.31
210302	Түлш, халаалт	9,328,500.00	7,267,536.42	2,060,963.58	77.91
210303	Цэвэр, бохир ус	2,854,500.00	4,647,963.35	1,793,463.35	162.83
2104	Хангамж, бараа материалын зардал	890,400.00	890,288.60	111.4	99.99
210401	Бичиг хэрэг	78,900.00	35,200.00	43,700.00	44.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,900.00	132,538.60	-68,638.60	207.42
210404	Ном, хэвлэл	49,400.00	24,600.00	24,800.00	49.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	146,300.00	163,150.00	-16,850.00	111.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	551,900.00	534,800.00	17,100.00	96.9
2105	Нормативт зардал	12,335,800.00	12,335,760.00	40	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,400.00	45,400.00		100
210502	Хоол, хүнс	11,854,900.00	11,854,860.00	40	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435,500.00	435,500.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,142,100.00		100
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,142,100.00		100
2107	Томилолт, зочны зардал	39,200.00		39,200.00	
210702	Дотоод албан томилолт	39,200.00		39,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,453,300.00	1,453,300.00		100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,453,300.00	1,453,300.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	368,264,500.00	366,667,044.28	1,597,455.72	99.57
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	352,218,500.00	352,131,661.00	86,839.00	99.98
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,218,500.00	352,131,661.00	86,839.00	99.98
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,046,000.00	14,535,383.28	1,510,616.72	90.59
132001	Орон нутгийн төсвөөс	16,046,000.00	14,535,383.28	1,510,616.72	90.59

5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	19	19		100
8	Үйлчлэх ажилтан	7	7		100

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

2-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тодорхойлсон бага насны хүүхдийн өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах сургалтын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын дотоод хяналтын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар:

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭД БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 377,619.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,664.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 3,965.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,694.9 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	61,879.1	52,582.1	-9,297.7
Үндсэн хөрөнгө	1,132,736.1	1,100,338.2	-32,397.9
Нийт хөрөнгө	1,194,972.6	1,153,277.7	-41,694.9
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/	1,194,972.6	1,153,277.7	-41,694.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,194,972.6	1,153,277.7	-41,694.9

2021 онд төсвийн урсгал санхүүжилтээр нийт 377,619.7 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвийн хуваарийн дагуу зардлыг зориулалт тус бүрээр зарцуулан сар бүр гүйцэтгэлийн мэдээ, улирал бүр санхүүгийн тайлан гарган цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ.

❖ Бараа материал

Тусгай зориулалтын материалын оны эхний үлдэгдэл 55,769.5 мянган төгрөг, тайлант хугацаанд 6,595.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 49,174.2 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Эм боох материалын оны эхний үлдэгдэл 1,112.3 мянган төгрөг, тайлант хугацаанд худалдаж авсан 120.4 мянган төгрөгийн эмийг орлогод авч, 759.9 мянган төгрөгийн зарлага гарган, 472.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

❖ Үндсэн хөрөнгө

2020 оны эхэнд 1,599,398.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байсан.

Барилга байгууламжийн эхний үлдэгдэл 820,434.5 мянган төгрөг, тайлант хугацаанд 23,605.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож, нийт хуримтлагдсан элэгдэл нь 70,815.5 мянган төгрөг, үлдэх өртөг нь 749,618.9 мянган төгрөг байна.

Машин тоног, төхөөрөмжийн эхний үлдэгдэл 51,236.1 мянган төгрөг, тайлант хугацаанд 3,285.5 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер, цахилгаан махны машиныг тус тус үндсэн хөрөнгөөр бүртгэж авсан. Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 31,664.0 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэл 4,326.4 мянган төгрөг, нийт элэгдэл 35,990.4 мянган төгрөг, үлдэх өртөг нь 18,531.1 мянган төгрөг байна.

Тавилга эд хогшилийн эхний үлдэгдэл 41,171.3 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 31,430.8 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэл 2,058.7 мянган төгрөг, нийт элэгдэл 33,489.6 мянган төгрөг, үлдэх өртөг нь 7,681.7 мянган төгрөг байна.

Зам, гүүрийн байгууламжийн эхний үлдэгдэл 71,750.7 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 6,681.4 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэл 5,612.9 мянган төгрөг, нийт элэгдэл 12,294.3 мянган төгрөг, үлдэх өртөг нь 59,456.3 мянган төгрөг байна.

Программ хангамжийн эхний үлдэгдэл 400.0 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 140.0 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэл 80.0 мянган төгрөг, нийт элэгдэл 220.0 мянган төгрөг, үлдэх өртөг нь 179.9 мянган төгрөг байна.

Биет ба биет бус хөрөнгө нь 2018 онд үндсэн хөрөнгө дахин үнэлсэнтэй холбогдож газар үнэлэгдсэн. Нийт өртөг нь 264,870.0 мянган төгрөг.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөгөө

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 465,094.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 465,094.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төлөвлөгөөг 377,619.7 мянган төгрөгөөр төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 377,619.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 377,619.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 368,264.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 366,667.0 мянган төгрөгийг зарцуулж 1,597.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 366,667.0 мянган төгрөг буюу 99.57 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн дансанд 355.0 мянган төгрөгийн санхүүжилт орсоноос, бичиг хэргийн зардалд 105.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 250.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгаан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 148 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 1 талбарын мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар няравын гаргаж байгаа бараа материалын тайланг нягтлан хянаж баталгаажуулдаггүй, гарын үсэг зурдаггүй анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй

байна гэсэн зөвлөмж өгсөн байна. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 100% хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,086.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,457.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 629.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй.

4.2 Албан шаардлага

1. Байгууллагын эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.-д “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2-д эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Бараа материалыг актлахдаа эрхлэгч тушаал шийдвэр гаргаж баталгаажуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1-д “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Дээрх 2 зөрчилд албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт хэсгийн мэдээллийг” 7 сард хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээллэж байх, хамаарах тушаал шийдвэрийг иж бүрэн үнэн зөв мэдээлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн 2 дугаар цэцэрлэг	3	4,086.2	0	0	0	0	2	3,457.0	1	629.2



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 53/55 011-90384/37/1111-СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 2-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.-д “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2-д “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.2-д “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 2-р цэцэрлэгийн эрхлэгч Л.Одонцэцэг, нягтлан бодогч Ш.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: О.ХЭРЛЭНЗАЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 15/55 АМ-2022/37/НА-СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 2-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтгүй 3,457.0 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтгүй бараа материал акталсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 2-р цэцэрлэгийн эрхлэгч Л.Одонцэцэг, нягтлан бодогч Ш.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: О.ХЭРЛЭНЗАЯА